



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 22 өдөр

Дугаар А/89

Улаанбаатар хот

Тээврийн хэрэгсэл бүртгэн авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт, 78 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 3.2.2-т заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тайваний Хүүхэд гэр бүлийг дэмжих сангаас хандивласан нийт 73,000,000.00 (далан гурван сая) төгрөгийн үнэ бүхий CWL50700WBCL3 арлын дугаартай, Dong fend маркийн тээврийн хэрэгслийг нийслэлийн өмчид бүртгэн авсугай.

2.Энэ захирамжийн нэгд заасан тээврийн хэрэгслийг балансад бүртгэн авч, ашиглалт хамгаалалтыг хариуцан ажиллахыг “Ус сувгийн удирдах газар” ОНӨААТҮГ (Ц.Төрхүү)-т үүрэг болгосугай.

3.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (М.Мөнхбаяр)-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

1110200326